

2008.05.08

Дугаар 112

“Мөнгөнбүрэн ББСБ” ХХК-д гадаад валютын
арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1.7, Хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Мөнгөнбүрэн ББСБ” ХХК-д гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2.Гадаад валютын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулан 2008 оны 05 дугаар сарын 25-ны дотор гэрчилгээний хуулбарыг Хороонд ирүүлэхийг “Мөнгөнбүрэн ББСБ” ХХК /С.Долгормаа/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ